| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 159,541,900.0 | 159,523,000.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 146,766,200.0 | 146,111,668.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 146,766,200.0 | 146,111,668.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 145,002,000.0 | 145,002,000.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,764,200.0 | 1,109,668.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,586,076,500.0 | 3,543,016,814.3 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,584,676,500.0 | 3,541,616,814.3 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,946,629,900.0 | 2,905,445,480.0 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | - | - |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 638,046,600.0 | 636,171,334.3 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 638,046,600.0 | 636,171,334.3 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,400,000.0 | 1,400,000.0 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,400,000.0 | 1,400,000.0 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.0 | 1.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.0 | 1.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 124.0 | 124.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 4.0 | 3.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 90.0 | 91.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 30.0 | 30.0 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 1,029.0 | 1,029.0 |
| **632** | **МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ** | 1,029.0 | 1,029.0 |
| 632001 | Төрийн өмчит МСҮТ | 1,029.0 | 1,029.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **120.0** | **124.0** |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | 88.0 | 88.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 32.0 | 36.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **200,541,850.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **200,541,850.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 200,541,850.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 5,409,600.0 |

| | | |
|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,409,600.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 800,400.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 800,400.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,742,000.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,065,220.0 |
| 210302 | Түлш, халаалт | 29,671,360.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,005,420.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 35,953,670.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,886,970.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 28,066,700.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 27,893,000.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 15,490,000.0 |
| 210602 | Тавилга | 6,603,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 5,800,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 34,288,451.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,259,587.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 6,028,864.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 61,454,729.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,292,960.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 51,161,769.0 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 467,144.0 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 200,541,850.0 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 200,541,850.0 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 62,682,000.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 40,525,272.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 31,915,200.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 65,886,522.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймаг дахь Хөгжил политехник коллеж нь: “Дэлхийд үнэлэгдэх чадамжтай мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ” алсын хараа, “Багшийн хөгжилд тулгуурлан дэвшилтэт техник, технологийг сургалт, үйлдвэрлэлд нэвтрүүлэн ур чадвартай мэргэжилтэй ажилтан бэлтгэдэг магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага болно” эрхэм зорилготойгоор “Мэргэжилтэй ажилтан-Хөгжлийн түлхүүр” уриатайгаар сургалтын үйл ажиллагаа зохион байгуулсан байна.

Суралцагчдыг барилга, уул уурхай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр мэргэжил эзэмшүүлэн, мэргэжлийн боловсрол олгохын зэрэгцээ, ажлын талбарт түншлэгч байгууллагад дадлагажуулж, төгсөгчдийг бүлэг болгон төсөл хөтөлбөрт хамруулж, сургуулийн дэргэдэх Бизнес инкубатор төвд бойжуулан, хөдөлмөрийн зах зээлд нийлүүлж байна. Тус коллеж нь нийт 35 дадлагын газар, 4 лаборатори, 10 туршилт сургалт үйлдвэрлэлийн баазтай бөгөөд нийт 124 ажилтан албан хаагч үүнээс 76 багштайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Боловсролын зэрэгтэй (доктор 2, магистр-30, бакалавр-37, дипломын-8) 76 багш, зөвлөх-5, тэргүүлэх-13, заах арга зүйч-32 багш байна. Нийт 33 хөтөлбөрөөр (барилга, уул уурхайн-12, үйлдвэр үйлчилгээ-10, хөдөө аж ахуйн-11) 1172 оюутан суралцаж байна. Үүнээс мэргэжлийн боловсрол- 2.5 жил 555 суралцагч, мэргэжлийн сургалт 1 жил-350 суралцагч, техникийн боловсрол 1.5 жил-85, 3 жилээр-182 хүн суралцан төгсөж байна. 2021-2022 оны хичээлийн жилд Барилга, дэд бүтэц-51, үйлдвэр үйлчилгээ-54, ХАА-18, нийт 123 бусад 24, нийт 147 аж ахуй, нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал 70.1 хувьтай байна.

Тус сургууль нь сургуулийн захирал – 1, сургалтын менежер – 1, захиргаа аж ахуйн менежер-1, арга зүйч багш – 3, мэргэжлийн болон ерөнхий эрдмийн 76 багш, үйлчилгээний албан хаагч - 42, нийт 124 багш ажиллагсадтайгаар сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Боловсролын тухай, Мэргэжлийн боловсролын тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Хөгжил политехник коллежийн захирлын 2022 оны 05 сарын 04-ны өдрийн А/56 тоот тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлуудыг зохион байгуулсан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөгжил политехник коллеж нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөгжил политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,179.6 сая төгрөгөөр буюу 90 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 52,705.7 | 0 | -52,705.7 |
| Бараа материал | 112,270.1 | 133,913.5 | 21,643.4 |
| Үндсэн хөрөнгө | 6,393,923.1 | 11,573,579.6 | 5,179,656.5 |
| **Нийт хөрөнгө** | **6,558,898.9** | **11,777,305.2** | **5,218,406.3** |
| Өр төлбөр | 0 | 285.0 | 285.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **6,558,898.9** | **11,777,020.2** | **5,218,121.3** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **6,558,898.9** | **11,777,305.2** | **5,218,406.3** |

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- 2021 оны эцэст 52.7 сая төгрөгийн авлагатай байсан. Тус авлага нь үндэслэлгүйгээр ажлаас халагдсан хүмүүстэй холбоотой авлага байсан ба 2022 онд БШУЯ-ны дотоод хяналтаас итгэмжлэл томилогдож шүүхэд нэхэмжлэл гаргаж шүүхийн шийдвэрийн дагуу авлагыг хүчингүй болгосон байна.
- Бараа материалын данс оны эхэнд 112.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан бол тайлант онд 727.7 сая төгрөгийн бараа материалыг өөрийн хөрөнгөөр болон бусад эх үүсвэр хандив тусламжаар авч 642.7 сая төгрөгийн бараа материал зарцуулж 133.9 сая төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна.
- Үндсэн хөрөнгө данс 960 хүүхдийн хичээлийн шинэ байрыг үндсэн хөрөнгөд бүртгэсэнтэй холбоотой 5.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Өр төлбөр 285.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх материалын өртэй гарсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,584.7 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 65.8 сая төгрөгөөр, төсөл хөтөлбөртэй холбоотой санхүүжилт 62.6 сая төгрөгөөр, Хөдөлмөрийн хэлтэс түр сургалтын орлого 31.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 40.5 сая төгрөг нийт зарлагыг 3,787.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 3,584.7 сая төгрөгөөр батлагдсан байна. Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,584.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 201.0 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 638.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийт 3,785.7 сая төгрөгийг бүрдүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,584.7 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 638.0 сая төгрөг, нийт 3,787.1 сая төгрөг бүрдүүлж, нэмэлт санхүүжилтээр 201.0 сая төгрөг бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,541.6 сая төгрөг 96.2 хувьтай байгаа бөгөөд 43.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Тусгай мэргэжлийн боловсрол / үндсэн үйл ажиллагаа 71804/80101 | 2,623,290.4 | 2,588,107.3 | 35,183.1 | 98,6% |
| 2 | Тусгай мэргэжлийн боловсрол / харуул хамгаалалт 71804/80219 | 32,173.3 | 27,159.4 | 5013.9 | 84.4% |
| 3 | Тусгай мэргэжлийн боловсрол / ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 71804/80802 | 146,766.2 | 146,111.6 | 654.5 | 99.6% |
| 4 | Тусгай мэргэжлийн боловсрол / дотуур байрны хоол хүнс 71804/81806 | 144,400.0 | 144,067.1 | 332.8 | 99.8% |
| 5 | Тусгай мэргэжлийн боловсрол / Төрийн өмчийн барилгын тогтмол зардал 71804/80111 | 541,975.0 | 541,940.7 | 34.2 | 98.6% |
| 6 | Тусгай мэргэжлийн боловсрол / Нийтлэг үйлчилгээ 71802/80112 | 96,071.6 | 94,230.6 | 1841.0 | 96.7% |
| **ДҮН** | | **3,584,676.5** | **3,541,616.7** | **43,059.5** | 96.2% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар хөдөлмөрийн хэлтсийн түр сургалтын орлого 31.9 сая төгрөг, төсөл хөтөлбөрөөр 62.7 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 65.9 сая төгрөг орон нутгаас 40.5 сая төгрөг нийт 201.0 сая төгрөгийг бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд 200.5 сая төгрөгийг зарцуулж 0.5 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Ховд аймаг дахь Хөгжил политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Аззаяа 2023 оны 02 дугаар сарын 19-ны өдрөөс 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 23 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,684.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 36.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 27.6 сая төгрөгөөр тогтоосон бол гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,348.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 43.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 32.6 сая төгрөгөөр тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

*Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.*

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 4,851.8 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 4,785.3 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 52.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 13.8 сая төгрөгийн 2 зөвлөмж өгчээ.

Үүнд: 960 хүүхдийн шинэ байр ашиглалтад орсонтойгоор санхүүжилтийн гүйцэтгэл дутуу, дээд шатны байгууллагаас үндсэн хөрөнгөд бүртгэхгүй гэсэн чиглэл ирсэн тул үндсэн хөрөнгөөс 4,765.6 сая төгрөгөөр бууруулж, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлыг буруу тооцсонтой холбоотой 19.7 сая төгрөгөөр бууруулж нийт 4,785.3 сая төгрөгийг залруулсан байна.

Байгууллагын авлага дансанд бүртгэлтэй 52.7 сая төгрөгийг Захиргааны ерөнхий хуулийн 103.2. "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасны дагуу дээд шатны байгууллагадаа уламжилж авлагыг барагдуулах арга хэмжээ авах талаар өгсөн албан шаардлагын биелэлт хангуулахаар иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж 153/ШШ2023/00109 дугаартай шүүхийн шийдвэрээр хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснээр авлага буурсан байна.

Байгууллагын дотоод хяналтын баг томилон малчин ангийн зардалд хяналт хэрэгжүүлэн, хоол хүнсний зардлыг бусад зардалд гүйлгэн зарцуулаагүй, томилолтоор ажилласан ажилчдаар томилолтын тайлан, илтгэх хуудас бичүүлж анхан шатны баримтын бүрдлийн хангаснаар зөвлөмжийн биелэлт хангагдсан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 1 | 52,705.7 | 1 | 52,705.7 | 100 |
| Зөвлөмж | 2 | 13,400.0 | 2 | 13,400.0 | 100 |
| **Нийт дүн** | **3** | **66,105.7** | **3** | **66,105.7** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ХОАДХПК/202204001 гэрээний худалдан авалт хийснээс хөдөлмөр хамгааллын хэрэгсэл ирээгүй урьдчилж гарсан зардлаар бүртгэснийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 397.6 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 397.6 сая төгрөгийн алдааг залруулав.

Үүнд: Үндсэн хөрөнгийн данс бүртгэлд машин тоног төхөөрөмж болох 334,320.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлгүй орхигдуулсан, хөдөлмөр хамгааллын хувцсыг нийлүүлэх 1 багц ажлыг хүлээж аваагүй байж шууд зардалд бүртгэсэн урьдчилж гарсан зардлаар бүртгэж тайлагнаагүй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна", Сангийн сайдын 2021 оны 190 тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байгаа тул залруулж бүртгэв.

Аудитаар нийт 19.0 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 17.9 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

- 2022 онд 1 багшийн зэргийн нэмэгдлийг илүү тооцож олгосон 413392 төгрөг, 1 багшийн үндсэн цалинг дутуу тооцож олгосон 676466 төгрөг бүгд 1089858 төгрөг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн "6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.3. "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн "20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэснийг зөрчсөн тул буцаан олгох, төсөвт төвлөрүүлэх акт тогтоов.

### 5.2 Зөвлөмж

### 1. Тендер худалдан авалттай холбоотой асуудал

***<u>Илрүүлэлт:</u> Нээлттэй тендер шалгаруулалтаар шалгарч хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл болон ажлын хувцас нийлүүлэх гэрээ байгуулсан аж ахуй нэгжийн гэрээнд заасан хугацаа мөрдүүлээгүй, төсөвт өртөг нэмэх талаар тооцоо судалгаа хийлгүйгээр нэмэлт санхүүжилт олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", ХОАДХПК/202204001 гэрээний 4.1 "Нийлүүлэгч нь захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолтын дагуу гэрээнд заасан хугацаанд чанар стандартад нийцсэн барааг нийлүүлнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй.***

*<u>Өгсөн зөвлөмж:</u>* Баян хүдэр ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж хугацаандаа чанар стандартын дагуу бараа материалыг хүлээн авах, төсөв нэмүүлсэн асуудлыг дотоод хяналтын баг томилж тооцоо судалгаа хийж, хяналт хэрэгжүүлэх

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u> Тайлант онд 5.2 сая төгрөгийн камер Төгс шимт оргил ХХК-наас худалдан авч хүлээн авсан болович үндсэн хөрөнгөд бүртгэж тайланд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2. "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалттай нийцээгүй.*

*<u>Өгсөн зөвлөмж:</u>* Байгууллагыг камержуулахтай холбоотой худалдан авсан хөрөнгийг данс бүртгэлд тусгаж алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Данс бүртгэлд тусгаагүй, буруу тусгасан | 2 | 397,662.0 | 1 | 334,320.0 | 1 | 63,342.0 | 2 | 397,662.0 | | | | |
| **Дүн** | **2** | **397,662.0** | **1** | **334,320.0** | **1** | **63,342.0** | **2** | **397,662.0** | **0** | **0** | **0** | **0** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан туш... | Тоо | Дүн |
| Тендер худалдан авалттай холбоотой зөрчил | 1 | 12,732.0 | | | | | 1 | 12,732.0 | 0 | 0 | 0 | 0 |
| Үндсэн хөрөнгийн бүртгэл | 1 | 5,236.0 | | | | | 1 | 5,236.0 | | | | |
| Зэргийн нэмэгдлийг илүү тооцож олгосон. | 1 | 413.4 | 1 | 413.4 | | | 0 | 0 | | | | |
| Үндсэн цалинг дутуу тооцон олгосон. | 1 | 676.5 | 1 | 676.5 | 0 | 0 | | | | | | |
| Дүн | **4** | **19,057.8** | **2** | **1,089.8** | **0** | **0** | **2** | **17,968.0** | **0** | **0** | **0** | **0** |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**АУДИТОР: Ц.АЗЗАЯА**